



**ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН
АЖЛЫН АЛБА**

Үйлдвэрчний гудамж 2, 20 дугаар хороо,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар, 17032,
Утас/Факс: (976) 7013 1609,
Цахим шуудан: office@nea.gov.mn,

2022-01-14 № 1/32
танай _____-ны № _____-т

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗАРТ**

Тус Ажлын албанаас Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2021 оны жилийн эцсийн хэрэгжилтийг үүгээр хүргүүлж байна.

Хавсралт 2 хуудастай.

ДАРГА



Т.МАНЛАЙЖАВ

03 0101

**Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
Цөмийн энергийн комиссын Ажлын алба
(2021 оны жилийн эцэс)**

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2021 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО							
1	2.1.3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан иргэд эх орондоо оношлогдон, эмчлүүлэх боломжийг нэмэгдүүлж, орчин үеийн үндэсний оношилгоо эмчилгээний төвүүдийг шинээр байгуулна.	10. Гадаадын тусламжийн хүрээнд эрүүл мэндийн салбарт цөмийн дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	2021–2022	ОУАЭА-ийн тусламж 66,800 евро	Туяа эмчилгээний дүрслэлийн тоног төхөөрөмж 1, төлөвлөлтийн систем 2, амьсгал зохицуулах аппарат 2, нийт 5 тоног төхөөрөмж суурилуулна.	<p>1. Олон Улсын Атомын Энергийн Агентлаг (ОУАЭА)-ийн Техникийн хамтын ажиллагааны хүрээнд 2020-2021 онд Хавдар судлалын үндэсний төв (ХСҮТ)-д “Шугаман хурдасгуурт суурилсан стереотактик туяа эмчилгээний аргыг нэвтрүүлж, түгээмэл тохиолддог хорт хавдрын эмчилгээний чанарыг сайжруулах нь” MON6021 төслийг хэрэгжүүлж байна. Төслийн нийт санхүүжилт нь 1,2 сая евро бөгөөд үүнээс ОУАЭА-аас 519,350 евро, Монгол Улсын Засгийн газраас 756,615 евро санхүүжүүлж, стереотактик эмчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг нийлүүлж, холбогдох хүний нөөцийг бэлтгэхээр төлөвлөсөн.</p> <p>- 2021 оны эцсийн байдлаар төслийн хүрээнд өвчтөний амьсгалын хөдөлгөөнийг барих төхөөрөмж “Abches”, өвчтөний амьсгалын хөдөлгөөнийг хянах 2 ширхэг камер, цацрагийн хяналтын дозиметрийн багаж, туяа эмчилгээний төлөвлөлт хийх сервер, шугаман хурдасгуурт аппаратын амьсгал хянах нэмэлт төхөөрөмж “Breath hold monitoring device” 2 ширхэг зэрэг нийт 385 мянган еврогийн үнэ бүхий тоног төхөөрөмжүүдийг Монгол Улс хүлээн авсан.</p> <p>- Дүрслэлийн төхөөрөмж (Onboard Imaging)-ийг Австрийн Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжиж буй “Хорт хавдрын навигаци болон стереотактик эмчилгээний төв байгуулах” төслийн хүрээнд шийдвэрлэхээр төлөвлөсөн байна.</p> <p>- Хүний нөөцийг бэлтгэх ажлын хүрээнд 7 эмч, физикч, техникчдийг 3 сараас 1 жил хүртэлх хугацаагаар Япон Улсын Хирошимагийн их сургуулийн эмнэлэгт стереотактик аргад сургаж, дадлагажуулахаар төлөвлөсөн бөгөөд цар тахлын нөхцөл байдлын улмаас хэсэгчилсэн сургалтыг цахимаар зохион байгуулж, явуулсан.</p> <p>2. Түүнчлэн ЭМЯ-ны хүсэлтээр тахлын үеийн бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээний ажлыг бэхжүүлэх, тусламж үйлчилгээний чадавхыг сайжруулах, тусламж үйлчилгээг алдагдуулахгүй байхад шаардагдаж буй тоног төхөөрөмж хэрэглэгдэхүүний жагсаалтыг ОУАЭА-т илгээж, Агентлагаас гишүүн орнууддаа цар тахалтай тэмцэхэд дэмжлэг үзүүлэх</p>	97

						<p>зорилгоор нийлүүлж буй буцалтгүй тусламжийн хүрээнд 113 сая төгрөгийн хэт авиан оношилгооны аппаратыг Хавдар судлалын үндэсний төвд, нийт 1.2 тэрбум төгрөгийн үнэ бүхий 5 ширхэг зөөврийн рентген аппарат зэргийг хүлээн авч, Хэнтий, Дорноговь, Ховд, Хөвсгөл, Сүхбаатар зэрэг 5 аймгийн Эрүүл мэндийн газруудад тус тус хүргүүлсэн. Мөн 83.5 сая төгрөгийн үнэтэй PCR оношилгооны машин, түүний РНХ ялгах урвалж бодис, оношилгооны кабинетын иж бүрдэл, 121 сая төгрөгийн үнэтэй зөөврийн рентген аппарат, 115 сая төгрөгийн лабораторийн жижиг хэрэглэгдэхүүн, урвалж бодисыг Халдварт өвчин судлалын үндэсний төвд хүргүүлсэн.</p>	
--	--	--	--	--	--	---	--

xxxXXxxx